



НЭР БҮХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ 20
КОМПАНИУДАД

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-17-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2016.06.20 № 9/2243.
танай _____-ны № _____-т

Мэдээлэл ирүүлэх тухай

Танай байгууллагыг Хорооны 2013 оны 453 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсэн.

Хорооноос тус журмын хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа хийгдэж байгаа тул журмыг хангаж байгаа талаарх дараах нотлох баримтыг 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг мэдэгдэж байна. Үүнд:

1. Орон тооны 2 үнэлгээчдийн тухайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
2. Хороо болон Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтээс зохион байгуулсан үнэт цаасны зах зээлийн талаарх төрөлжсөн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;
3. Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
4. Үнэлгээчид нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтийн тодорхойлолт.

Тогтоосон хугацаанд нотлох баримтыг бүрэн ирүүлээгүй тохиолдолд тус журмын 4.4.2-т заасан шаардлагыг хангахгүй болсон гэж үзэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.6-д “Хороо нь үнэт цаасны зах зээлд аудитын, хөрөнгийн үнэлгээний болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу танай байгууллагыг үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасах болохыг мэдэгдэж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА



Б.ОЮУНЦАЦРАЛ

002591